

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ: БАРИЛГЫН ЗӨВШӨӨРӨЛ АВАХ

Шинэчлэлийн шаардлага: “Бизнес эрхлэх нь 2012” судалгааны “Барилгын зөвшөөрөл авах” шалгуур үзүүлэлтээр судалгаанд хамрагдсан 183 орноос Монгол Улс 119-р дүгээр байрт оржээ. Монголд барилгын зөвшөөрөл авах нь нилээд төвөгтэй процесс бөгөөд нийт 19 шат дамжлага дамжиж, 208 хоног зарцуулж, төрийн эрх бүхий 12 байгууллагаар орох шаардлага гардаг. Зөвхөн барилгын ажил эхлүүлэх тусгай зөвшөөрөл авахад 10 шат дамжиж, 155 хоног зарцуулан, 8-аас доошгүй эрх бүхий байгууллагаар орж, асуудлаа шийдвэрлүүлдэг. Түүнчлэн инженерийн шугам сүлжээний холболт, хяналт шалгалтад 39 хоног, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд барилгаа бүртгүүлэхэд 14 хоног тус тус зарцуулдаг. Харин Гүрж Улсад барилга барих зөвшөөрөл авахад 3 шат дамжлага дамжиж, 41 хоног, үүний дотор инженерийн шугам сүлжээний холболтод 32, барилгыг бүртгүүлэхэд 1 хоног зарцуулж, эрх бүхий 2 байгууллагаар орж шийдвэрлүүлдэг байна. Зүүн Ази, Номхон Далайн бүсийн 24 орноос дээрх үзүүлэлтээр Монгол Улс 21 дүгээр байрт орж байгаа бөгөөд барилгын зөвшөөрөл олгох асуудлаа нарийвчлан үзэж, өөрчлөх шаардлагатай байгаа юм. Монгол Улс барилгын зөвшөөрөл олгох шат дамжлагаа 6-гаар цөөлж, хянан шийдвэрлэх хугацаагаа 60 хоногоор бууруулж чадвал “Бизнес эрхлэх нь 2014” судалгааны “Барилгын зөвшөөрөл авах” шалгуур үзүүлэлтээр одоогийн 119 дүгээр байраас 46 дугаар байрт ахих боломжтой. Түүнчлэн барилгын зөвшөөрөл олгох ажиллагааг дахин төлөвлөж, хялбаршуулан ил тод болгосноор одоогийн гарч буй зардлыг 30 хувиар хэмнэх тооцоо гарч байна.

Шинэчлэлийн зорилт: Монголд барилгын зөвшөөрөл олгох ажиллагааг олон улсын шилдэг туршлага, арга ажиллагаатай нийцүүлэн илүү хялбар, шуурхай, ил тод, хямд болгож өөрчлөх.

Хэрэгжүүлэх механизм: Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ)-аар ахлуулсан, хувийн хэвшлийн төлөөлөл багтсан Ажлын хэсэг, Техникийн зөвлөх багийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ:



Нөөц бололцоо: Төрийн байгууллагуудын мэргэжилтнүүд, бизнесийн холбоодын төлөөлөгчид. Онлайн бүртгэлийн системийг боловсруулахад АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн Бизнесийг Дэмжих Санаачилга төсөл, Эдийн Засгийн Бодлого, Өрсөлдөх Чадварын Судалгааны Төв, Азийн Хөгжлийн Банк болон бусад байгууллага техникийн туслалцаа, дэмжлэг үзүүлнэ.

Үүрэг, хариуцлага: БХБЯ Ажлын хэсгийг ахалж, төлөөллийн мэргэжилтнүүдийг томилж, төрийн бусад байгууллагууд, мэргэжлийн холбоод өөрсдийн төлөөллийг томилно. Техникийн зөвлөх баг нь Ажлын хэсэгт техникийн туслалцаа, дэмжлэг үзүүлнэ.

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд: Үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр хэмжинэ. Үүнд:

1. Барилгын зөвшөөрөл авахад шаардагдах шат дамжлагын тоог цөөлсөн байдал
2. Барилгын зөвшөөрөл авахад зарцуулах хоног, зардлыг бууруулсан байдал
3. Барилгын зөвшөөрөл авахтай холбоотой хууль эрх зүйн, зохицуулалтын болон захиргааны чанартай зохицуулалтыг өөрчлөх талаар тусгайлсан зөвлөмжүүд

Үр дүнгийн явц, ахиц дэвшилд мониторинг хийх, тогтмол тайлагнах: Ажлын хэсэг нь гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд тогтоосон зорилтуудын явц, ахицыг тогтмол тайлагнана.

Шинэ Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн эхний жилд санал болгож буй ажлууд: Дээрх шинэчлэлийг хэрэгжүүлэхэд санал болгож буй ажлууд болон тэдгээрийн графикт хугацааг дараагийн хуудсанд тайлбарлав.

БАРИЛГЫН ЗӨВШӨӨРӨЛ АВАХ: САНАЛ БОЛГОЖ БУЙ ГОЛ АЖЛУУД, ТЭДГЭЭРИЙН ГРАФИКТ ХУГАЦАА

САНАЛ БОЛГОЖ БУЙ ГОЛ АЖЛУУД	2012 оны 10-12 сар	2013 оны 1-3 сар	2013 оны 4-6 сар	2013 оны 7-9 сар	Тайлбар
<i>Эрх зүй, зохицуулалт, захиргааны шинэчлэлүүд</i>					
1 Барилга, хот байгуулалтын яамаар ахлуулсан, орон нутгийн засаг захиргаа, төрийн холбогдох байгууллага, орон нутгийн засаг захиргаа, хувийн хэвшлийн мэргэжилтнүүдээс бүрдсэн Ажлын хэсгийг байгуулах	<input type="checkbox"/>				
2 Олон Улсын Барилгын Норм Дүрмийн Зөвлөлийн стандарт зэрэг олон улсад мөрдөгддөг барилгын норм стандарт, шилдэг туршлагад тулгуурласан цогц, дэвшилтэт барилгын норм дүрмийг шинээр боловсруулах	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
3 Олон улсын шилдэг туршлагад тулгуурлан дүрэм журмыг хялбаршуулах, хэрэгцээгүй шат дамжлагыг цөөлөхөд шаардлагатай хууль эрх зүй, зохицуулалтын өөрчлөлтүүдийг тодорхойлох; цаг хугацаа, зардлыг бууруулах, төрийн эрх бүхий байгууллагуудаас шаарддаг бичиг баримт (жишээ нь, барилгын зураг төсөл, талбайн зураг), мэдэгдэл, хяналт шалгалт, тэдгээрийг хүргүүлэх процессын ил тод байдлыг сайжруулах	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
4 Монголын барилгын салбарт иргэний хариуцлага болон хариуцлагын даатгалын тогтолцоог бий болгох			<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
<i>Барилгын зөвшөөрөл олгох журмыг хялбаршуулж, хэрэгцээгүй шат дамжлагыг цөөлөх шинэчлэлүүд</i>					
5 Барилгын зөвшөөрөл авахад зарцуулж буй хугацаа, зардлыг дорвитой бууруулж чадах хууль эрх зүй, зохицуулалт, дүрэм журам, үйл ажиллагааг өөрчилж олон улсын шилдэг туршлагад нийцүүлэн хялбаршуулах	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6 Жижиг байр, гаднах зар сурталчилгааны самбар зэрэг овор багатай байгууламж барихад авах зөвшөөрлийн журмыг хялбаршуулан боловсруулж, мөрдүүлэх, цахилгаан, утас, ус зэрэг ахуйн хэрэглээний холболтын зөвшөөрлийн журмыг хялбаршуулах боломжийг тодорхойлох		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
7 Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн хүрсэн түвшингийн талаар Ажлын хэсгээс <i>Олон нийтэд зориулсан улирлын явцын тайлан</i> гаргах (3 хуудаснаас дээшгүй)		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<i>Ажлын хэсгийн үйл ажиллагаанд онцгой хувь нэмэр оруулсан төрийн албан хаагчид, бизнесийн төлөөлөгчдийг шагнаж урамшуулах Цагаан Сар Үдшийн зоог арга хэмжээ</i>

БАРИЛГЫН ЗӨВШӨӨРӨЛ АВАХ: САНАЛ БОЛГОЖ БУЙ ГОЛ АЖЛУУД, ТЭДГЭЭРИЙН ГРАФИКТ ХУГАЦАА

САНАЛ БОЛГОЖ БУЙ ГОЛ АЖЛУУД	2012 оны 10-12 сар	2013 оны 1-3 сар	2013 оны 4-6 сар	2013 оны 7-9 сар	Тайлбар
8 Барилгын зөвшөөрөлтэй холбоотойгоор бизнес эрхлэгчдэд шаардагддаг болон төрөөс гарч буй зардал, хугацааг бууруулах, ил тод байдлыг сайжруулахын тулд барилгын зөвшөөрлийг вэбэд суурилсан хэлбэрээр олгох тогтолцоог бий болгох		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
9 Барилгын зөвшөөрөл олгох шинэ журмын талаарх мэдээллийг, үүний дотор лавлах үйлчилгээний төвийн ажиллагаа/протоколын талаар тус салбарт ажиллагсад, олон нийтэд таниулж сургах олон нийтийн харилцааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
10 Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ, зөвлөмжүүдийг багтаасан <i>Олон нийтэд зориулсан Ажлын хэсгийн эцсийн тайлан</i> гаргах (5 хуудаснаас дээшгүй)				<input type="checkbox"/>	